

МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17-дөр

Дугаар А/368

Зуунмод

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сум, Номт 1-р баг, Энхжин хотхон, Лувсангомбын гудамж, 408 тоот хаягт газар эзэмших эрхийн 000027829 дугаар бүхий гэрчилгээтэй иргэн Бодь овогтой Петрийн эмнэлгийн зориулалттай 1608 м² газраас 1079 м² газрыг иргэн Ширнэн овогтой Уранчимэг /НЭ54030861/-т эмнэлгийн зориулалтаар хэсэгчлэн шилжүүлж, үлдсэн 529м² газрыг Б.Петр /ЧЙ53082577/-т амины орон сууцны зориулалтаар тус тус 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Б.Петр, Ш.Уранчимэг нарт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2 Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3 Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга/Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.


3.1 Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2 Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/153 дугаар захирамж болон газар эзэмших эрхийн 000027829 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 01150